



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№80 /293/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.04.23

Цаг үе, үйл явдал

## БАТЛАН ХАМГААЛАХЫН ДЭД САЙД Б.БАЯРМАГНАЙ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 011 ДҮГЭЭР АНГИД АЖИЛЛАЛАА



Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, ЗХЖШ-ын орлогч дарга, бригадын генерал Ч.Цогтжаргал, БХЯ-ны БХЗГ-ын дарга, хурандаа Б.Түвшинтөр, ЗХЖШ-ын Материал, техникийн газрын дарга, бригадын генерал М.Мөнхбаяр нар Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 011 дүгээр ангид ажиллалаа. Тус ангийн захирагч, хурандаа М.Батдорж ангийн товч танилцуулга, үндсэн үүрэг, өдөр тутмын үйл ажиллагаа, энэ онд хийгдэх зарим бүтээлч ажлууд болон хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн талаар танилцуулсан юм. Тус анги нь салбарын хэмжээнд цэргийн зориулалт

бүхий автомашины дугаар, лацны дартсаас эхлээд зэвсэг техникийн засвар үйлчилгээ, сэргээн сайжруулалтыг гардан гүйцэтгэдэг. Үүнээс гадна гарын доорх материал, нөөц боломжоо ашиглан бэлэг дурсгалын зүйлс, төрөл бүрийн хутга зэргийг урладаг батлан хамгаалах салбарын үйлдвэрлэгч анги юм. Ангийн захирагч, хурандаа М.Батдорж цаашид инженерийн шугам засварын ангиас үйлдвэрийн анги болох зорилт тавин ажиллаж байгаагаа хэлж байлаа. Мөн энэ үеэр тус ангид тулгамдаад байгаа хэд хэдэн асуудлыг Батлан хамгаалахын дэд сайдад илэрхийллээ.



### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 2	☁️ -7

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 38	☁️ 25

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,085.00	3,110.0
EUR 🇪🇺	3,380.0	3,420.0
CNY 🇨🇳	483.00	489.00
RUB 🇷🇺	37.00	37.50
JPY 🇯🇵	25.00	26.00
KRW 🇰🇷	2.55	2.62

### ЗУРХАЙ



2022.04.26 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 26/

**ХАВРЫН АДАГ ХӨХ ЛУУ САРЫН ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ТАХИА ӨДӨР**

**Үс засуулбал:**  
**ЖАРГАЛ ҮРГЭЛЖИД ИРНЭ**  
**НАРАН УРГАХ, ШИНГЭХ:**  
**05.43-19.57**  
**Барилдлага:**  
**Түлэх**  
**ШҮТЭН БАРИЛДЛАГА:**  
**Сэрэхүй**  
**Суудал: Шороо**


## СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН “ДӨЛ” ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНД 280 ГАРУЙ СУРАГЧ ОРОЛЦОЖ, ХУРД ХҮЧЭЭ СОРИЛОО



Сонгинохайрхан дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд цэрэг спортын “Дөл” цогцолбор тэмцээн өнгөрөгч амралтын өдрүүдэд Зэвсэгт хүчний 013 болон 084 дүгээр ангид зохион байгуулагдлаа. Энэхүү тэмцээнийг өсвөр үеийнхэнд цэрэг, эх оронч хүмүүжил олгох, эх орноороо бахархах үзлийг төлөвшүүлэх, тэдний бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэл, тэсвэр хатуужил олгох, ирээдүйн мэргэжлээ зөв сонгоход нь дэмжлэг үзүүлж, Зэвсэгт хүчний залгамж халааг бэлтгэх зорилготойгоор жил бүр зохион байгуулагддаг уламжлалтай. Энэ жилийн тэмцээнд дүүргийн ерөнхий боловсролын 20 сургуулийн 280 гаруй сурагчид жагсаал, гардан тулаан, химийн норматив, галын бэлтгэл, эсээ бичлэг, эмнэлгийн тусламж, урлагийн үзүүлбэр болон маршийн гүйлтийн төрлүүдээр хурд, хүч, авхаалж самбаа, мэдлэг чадвараа сорин өрсөлдөж, аваргуудаа тодрууллаа.

1 дүгээр байрт 124 дүгээр сургууль, 2 дугаар байрт 105 дугаар сургууль, 3 дугаар байрт 65 дугаар сургууль, тусгай байр: 153 болон 78 дугаар сургууль “урлагийн үзүүлбэр” - 67 дугаар сургуулийн багууд тус тус шалгарлаа. Мөн “тэргүүний жагсаалч”-аар 65 дугаар сургуулийн баг шалгарсан бол “шилдэг гранат шидэгч” эрэгтэй тамирчнаар 9 дүгээр сургуулийн сурагч Б.Мягмардорж, “шилдэг гранат шидэгч эмэгтэй тамирчин”-аар 76 дугаар сургуулийн сурагч Б.Баясгалан, “шилдэг эрэгтэй” тамирчнаар 121 дүгээр сургуулийн сурагч Д.Ундрахбаяр, “шилдэг эмэгтэй” тамирчнаар 153 дугаар сургуулийн сурагч С.Шүрэнцэцэг, “тамирчин дайчин” сурагчаар 76 дугаар сургуулийн сурагч Б.Гэсэр, “онц буудагч” сурагчаар 62 дугаар сургуулийн сурагч Б.Мөнгөнцэцэг нар тус, тус шалгарлаа.

Мөн тэмцээний тэргүүн байранд шалгарсан 124 дүгээр сургуулийн баг ирэх наймдугаар сард болох Улсын аварга шалгаруулах “Дөл” тэмцээнд дүүргээ төлөөлөн өрсөлдөх эрхтэй болж байгаа юм.



## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН 2,272,84 /69.9%/	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН 2,175,35 /66.9%/	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН 1,037,670 31,9% 120,959 /3,7%/
НИЙТ БАТЛАГДСАН 8455 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 6	ЭДГЭРСЭН 8321

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 510,059,143
Эдгэрсэн Нийт: 463,086,050
Нас барсан Нийт: 6,245,375

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН САНААЧИЛГААР  
2022.05.01-НЭЭС ЭХЛЭН

ОРОН ДАЯАР ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ЭРТ ИЛРҮҮЛЭХ ҮЗЛЭГТ

БАРЬС	БАРЬС	БАРЬС	БАРЬС	БАРЬС
0-5 НАС	6-17 НАС	18-30 НАС	31-45 НАС	46-60 НАС
61+				

Цахим шууданд

“АЛДАР” СПОРТ ХОРОО

## АЗИЙН ШИЛДГҮҮД 21 ЖИЛИЙН ДАРАА УЛААНБААТАРЫН ДЭВЖЭЭНД ӨРСӨЛДӨВ



Бөхийн төрлүүдийн 2022 оны насанд хүрэгчдийн Азийн аварга шалгаруулах тэмцээн дөрөвдүгээр сарын 19-24-нд Монгол Улсын нийслэл Улаанбаатарт боллоо. Эрэгтэйчүүдийн 35, эмэгтэйчүүдийн 24, сонгомол бөхийн 31 дэх удаагийн тэмцээнд Монгол, Бахрейн, БНСУ, Иран, Ирак, Йордан, Кыргызстан, Катар, Казахстан, Кувейт, Пакистан, Палестин, Тажикистан, Туркменистан, Сингапур, Сири, Узбекистан, Шри-Ланка, Энэтхэг, Япон гэсэн 20 орны 250 гаруй тамирчин бөхийн гурван төрөлд өрсөлдөв. 21 жилийн дараа эх орондоо Азийн аварга шалгаруулах тэмцээнийг эх орондоо хүлээж авсан Монгол Улс нутгийн дэвжээн дээрээ эмэгтэй бөхчүүд

дөрвөн мөнгө, таван хүрэл, эрэгтэйчүүд хоёр мөнгө, нэг хүрэл медальтай тэмцээнээ өндөрлүүлээ. Үүнээс Зэвсэгт хүчний “Алдар” спорт хорооны гавьяат дасгалжуулагч Ц.Хосбаяр, гавьяат тамирчин Г.Мандахнаран, Б.Одончимэгл дасгалжуулагчтай 8 тамирчин оролцож, 55 кг-ийн жинд ОУХМ Г.Отгонжаргал мөнгө, 72 кг-ийн жинд ОУХМ Э.Даваанасан хүрэл, 125 кг-ийн жинд ОУХМ Э.Батмагнай хүрэл медаль тус тус хүртлээ. Сонгомол бөхийн 60 кг-ийн жинд Ц.Балжинням, 55 кг-ийн жинд М.Даваабанди, чөлөөт бөхийн 65 кг-ийн жинд Ц.Цогбадрах нар шагналт байрыг тус тус эзэллээ.

## Б.ОРХОНБАЯР ХАРЦАГА ТҮРҮҮЛЛЭЭ

Сонгинохайрхан дүүргийн 30 жилийн ойд зориулсан “Сонгинохайрхан уулын хишиг” улс, аймгийн алдар цолтой эрэмбэ, чансаатай хүчит 128 бөхийн барилдаанд Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын харьяат, “Алдар” спорт хороо “Хос түрүү” ХХК, “Атар трейд” ХХК, Таван-Хан дэвжээний бөх, улсын харцага Б.Орхонбаяр түрүүлж, Говь-Алтай аймгийн Жаргалан сумын уугуул, Ховд аймгийн Буянт сумын харьяат, “Аврагч” спорт хороо,

“Од” групп, “Их Монгол” Сан, “Эм Жи Ө транс” ХХК, “Ховд” дэвжээний бөх, улсын харцага О.Хангай үзүүрлэв. Их шөвөгт Булган аймгийн Сэлэнгэ сумын харьяат, “Нью Майнд” групп, “Булган Хан” дэвжээний бөх, улсын начин Д.Амарсайхан, Төв аймгийн Өндөрширээт сумын харьяат, “Сүлд” спорт хороо, “Заамар өгөөж хайрхан” ХХК, Дүнжингарав дэвжээний бөх, улсын начин Д.Хүдэрбулга нар шалгарлаа.



## ДЭЛХИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ЭРХЭЭ АВЛАА



Энэ сарын 10-нд Голландын Роттердам хотноо жил бүр уламжлан болон явагддаг 41 дэх удаагийн “NN Marathon Rotterdam 2022” марафонд Монголын марафон гүйгч ОУХМ ахлагч Б.Мөнхзаяа 2:29:25 амжилтаар дөрөвдүгээр байрт орлоо. Мөн 4 дүгээр сарын 16-нд Өмнөд Солонгос улсад зохион байгуулагдсан

“Сөүл 2022” олон улсын марафон (42.195) тэмцээнд “Алдар” спорт хороо, Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн ахлах ахлагч ОУХМ Ц.Бямбажав 2:11:23 амжилтаар тус тус АНУ-ын Орегон мужийн Южин хотноо зохиогдох дэлхийн аварга шалгаруулах хөнгөн атлетикийн тэмцээнд оролцох эрхээ авлаа.

## АХМАД ДАЙЧДЫГ ХҮЛЭЭН АВЧ ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



**Зэвсэгт хүчний 353 дугаар анги**  
Алтан гадас одонт дэслэгч генерал Ч.Пүрэвдоржийн нэрэмжит Зэвсэгт хүчний 353 дугаар анги энэ сарын 25-ны өдөр тус ангид итгэл зүтгэл, бие сэтгэлээ зориулан ажиллаж байсан эрхэм хүндэт ахмад дайчдыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгууллаа. Дэлхий дахинд үүссэн Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан ахмад дайчдаа 2 жилийн хугацаанд хүлээж аваагүй байсан тул энэ удаа зохион байгуулсан хүндэтгэлийн арга хэмжээнд анги байгууллагаас гавьяаныхаа амралтад гарсан, бэлтгэл чөлөөнд байгаа 100 орчим ахмад дайчид идэвхтэй хамрагдаж нэг өдрийн ангийн

байрлалд хуучин цагаа дурсан, анд нөхөхтэйгөө уулзсан нөхөрсөг уулзалт боллоо. Ахмад дайчдыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ ангийн захирагчаар батлагдсан хөтөлбөрийн дагуу ахмад дайчдыг хүлээн авах угтах алдрын тасалгаа болон төр нийгмийн нэрт зүтгэлтэн дэслэгч генерал Ч.Пүрэвдорж агсны нэрэмжит танхимтай танилцах ангийн танилцуулга, урлагийн тоглолт, шагнал гардуулах ажиллагаа, Байлдааны туганд хүндэтгэл үзүүлэх ажиллагаа, дурсгалын зураг авалт, хүндэтгэлийн зоог, гарын бэлэг, гардуулах үдэшлэгийн арга хэмжээ гэсэн дараалалтайгаар зохион байгуулагдлаа.  
**Ахмад Б.ГАНЧУЛУУН**



## УДИРДАХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

**Увс аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб**  
Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 9 дүгээр зүйл, Батлан хамгаалахын сайдын Увс аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээний 4.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2022 оны А/202 дугаар захирамжийг үндэслэн Түргэн,

Сагил, Тариалан, Наранбулаг сумуудад Батлан хамгаалах хууль сурталчлахын зэрэгцээ, Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүн, томилгоот нэгжийн сургалтыг энэ сарын 12-16-ны хооронд зохион байгууллаа.

**Хошууч Ж.ЦЭРЭНЧИМЭД**



## “ЭХ ДЭЛХИЙН ӨДӨР”-ӨӨР...



**Зэвсэгт хүчний 284 дүгээр анги**  
“Эх дэлхийн өдөр” буюу энэ сарын 22-ний өдөр ангийн бие бүрэлдэхүүн амьдарч байгаа эх дэлхий, гэр орон, ойроон хайрлан

хамгаалах, ирээдүйн төлөө, хүн нэг бүрийн дуу хоолой, хөдөлмөрийг нэгтгэн илүү их хор уршиг тарахгүй төлөө “Гачуурт”-ын Хар усан тохойн эрэг дагуух цэвэрлэгээг зохион байгуулан явууллаа.

## 20 ЖИЛИЙН ОЙН ХҮРЭЭНД...



“Налайхын цэнхэр хөндий” урлагийн наадам болж өндөрлөв. Тус наадамд орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жил, Налайхын их уурхайн 100 жил, Монгол улсын Зэвсэгт хүчин НҮБ-ын болон олон улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойд зориулан Налайх дүүргийн ЗДТГ-аас тус дүүрэг дэх Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд зохион байгуулж

явуулсан “Налайхын цэнхэр хөндий” урлагийн наадам энэ сарын 23-ны өдөр зохион байгуулсан юм. Тус наадамд Зэвсэгт хүчний 353 дугаар анги тэргүүн байрт, Зэвсэгт хүчний 014 дүгээр анги дэд байрт тус тус шалгарлаа.  
**Зэвсэгт хүчний 014 дүгээр анги Хошууч Э.Хашцахиур Зэвсэгт хүчний 353 дугаар анги Ахмад Б.НАНДИНЦЭЦЭГ**